

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАРИМ СУМЫН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН АЛБАН  
ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр

Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалт, “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 2.3-т заасны дагуу **Хужирт сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн, Баруунбаян-Улаан сумын цэцэрлэгийн эрхлэгчийн, Зүүнбаян-Улаан сумын цэцэрлэгийн эрхлэгчийн, Уянга сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн, Богд сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн** албан тушаалын сонгон шалгаруулах зарыг олон нийтэд тус тус мэдээлж байна.

Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу зохион байгуулж явуулна. ([Журмыг энд дарж үзнэ үү.](#))

**Нэг. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх иргэнд тавигдах болзол**

- Монгол Улсын иргэн байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй байх;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан байх.

**Хоёр. Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага [/энд дарж зөвлөмжтэй танилцана үү/](#)**

<b>Боловсрол</b>	- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
<b>Мэргэжил</b>	- Сургуулийн өмнөх боловсролын багш, арга зүйч
<b>Мэргэшил</b>	- Боловсролын болон төрийн удирдлага, нийгмийн удирдлагын аль нэг чиглэлээр, - Бага насны хүүхдийн хөгжил, сургуулийн өмнөх боловсролоор мэргэшсэн байх; - Судалгааны арга зүй, сурган хүмүүжүүлэх туршилтын арга зүй, менежмент; - Сургалтын байгууллагын менежмент, хүний нөөцийн удирдлага
<b>Туршлага</b>	- Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон төрийн байгууллагад 5 болон түүнээс дээш жил ажилласан байх; - Багшлах болон удирдах ажилтнаар ажилласан дадлага туршлагатай байх; - Мэргэшлийн зэрэгтэй байх

<b>Ур чадвар</b>	<p>Дүн шинжилгээ хийх:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх</li> <li>- Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах</li> <li>- Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй</li> </ul> <p>Асуудал шийдвэрлэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах</li> <li>- Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах</li> </ul> <p>Багаар ажиллах:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах</li> <li>- Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох</li> </ul> <p>Бусад:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар</li> </ul>
------------------	--

### **Гурав. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг**

- Төрийн албан хаагчийн анкет “А хэсэг” болон “Б хэсэг”; ([анкетыг энд дарж татаж авна үү](#))
- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;
- Иргэний үнэмлэхний хуулбар, эх хувийн хамт;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн хуулбар, эх хувийн хамт; /Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах/
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт;
- Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, эх хувийн хамт; /албан тушаалын тодорхойлолтын туршлагын шаардлагад заасны дагуу ажилласныг нотлох тушаал, шийдвэрийг холбогдох байгууллагаас хуулбарлан авч ирэх бөгөөд байгууллагын “Хуулбар үнэн” даруулж хавсаргах/
- “4 х 6”-гийн хэмжээний 2 хувь цээж зураг;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт;
- Шалгалтын үйлчилгээний зардал.

Дээр заасан баримт бичгийг дутуу бүрдүүлсэн, зохих ёсоор бүрдүүлээгүй иргэнийг бүртгэхгүй.

### **Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах ба бүртгэх**

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт болон бүрдүүлсэн баримт бичгийг аймгийн Засаг даргын дэргэдэх **Боловсрол, соёл, урлагийн газрын 411 тоот өрөөнд 2020 оны 1 дүгээр сарын 6, 7-ны өдрүүдэд** 09:00-13:00, 14:00-18:00 цагийн хооронд комисс хүлээн авна.

Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх болзлыг хангаж, холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн албан хаагчийг бүртгэх тухай шийдвэрийг комисс хуралдаанаараа гаргах бөгөөд болзол хангаагүй бол энэ тухай шалтгааныг мэдэгдэнэ.

### **Тав. Сонгон шалгаруулалтын хуваарь**

**2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр** сонгон шалгаруулалтыг доорх агуулгын хүрээнд зохион байгуулна. Үүнд: [үншиж судлах эрх зүйн баримт бичгийн жагсаалтыг энд дарж үзнэ үү.](#)

1. Оролцогчид албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж буй байдлын үнэлгээ;
2. Тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг;
3. Дүн шинжилгээ хийх чадвар;
4. Асуудал шийдвэрлэх чадвар;
5. Монгол хэлний бичгийн чадвар, Цахим орчин, компьютерийн хэрэглээний програм ашиглах чадвар;
6. Удирдан зохион байгуулах чадвар;
7. Манлайлах чадвар;
8. Багаар ажиллах чадвар.

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад оролцох иргэн “Иргэний цахим үнэмлэх”-ээ үзүүлж шалгалт өгнө.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

Холбоо барих утас: 70323538, 99143444